



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 01/53

Улаанбаатар хот

2011 онд мөрдөх “Хүн амын амьжиргааны”  
доод түвшин”-г тогтоох тухай

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Үндэсний статистикийн газрын даргын 2005 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 01/134 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Монгол Улсын хуулийн хүрээнд Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлал”-ын дагуу тооцсон “Хүн амын амьжиргааны 2011 оны доод түвшин”-ий хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталж 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

Хоёр. Шинэчлэн баталсан “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий хэмжээг холбогдох байгууллагад албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Ганбат/-т даалгасугай.

Гурав. Хүн амын ядуурал, амьжиргааны түвшинг тодорхойлж байгаа өнөөгийн байдалд дүгнэлт өгч, санал боловсруулах ажлын хэсэг байгуулан, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, үр дүнг 2011 оны 7 дугаар сарын 1-ний дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Үндэсний статистикийн хорооны дэд дарга /Б.Эрдэнэсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН



Үндэсний статистикийн хорооны даргын  
2011 оны .../... сарын ... -ны өдрийн  
.../... тоот тушаалын хавсралт



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	104300
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	105100
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	106600
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	103500
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	118100